



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/883

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийг дэмжих “Шинэ хөдөө” төслийн хүрээнд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжүүдийг ард иргэдэд хүртээмжтэй хүргэхэд зориулан журам боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Гомбосүрэн (Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)

Гишүүд: Ц.Нанжид (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Захиргаа аж ахуйн албаны дарга)

Г.Энхмаа (Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн тасгийн тооцооны нягтлан)

Х.Болормаа (Засаг даргын Тамгын газрын Санхүү, аж ахуйн тасгийн нярав)

Б.Наранбаатар (“Шинэ Ховд” Үйлдвэрлэл технологийн паркийн дарга)

Ж.Онончулуун (“Шинэ Ховд” бизнес хөгжлийн төвийн менежер)


Нарийн бичгийн дарга: Ц.Пүрэвсүрэн (Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

8400001 2128

Zah A/883 Ba

2. “Шинэ хөдөө” төслийн нийлүүлэгдэх тоног төхөөрөмжүүдийн журмыг хуулийн хүрээнд судалж боловсруулж, хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Гомбосүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Х.БАТБОЛД